



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/62

Хархорин сум

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга
хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6, 9.8.1, 9.8.2 дахь заалт, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/242 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, хийж гүйцэтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Батчулуун (Орлогч дарга)
Гишүүд: Ц.Пүрвээ ("Дэлийн бүрд" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эмч)
А.Сайнбилэг ("Аяган зураа" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эмч)
Б.Нямсүрэн ("Өвдөлгөөн ундарга" мал эмнэлгийн
үйлчилгээний нэгжийн эмч)
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Гантөмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Ө.Энхжаргал (4 дүгээр багийн Засаг дарга)
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)
Ц.Гомбосүрэн (8 дугаар багийн Засаг дарга)
Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Тархвар зүйч)

2. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл технологит хугацаанд нь хийж гүйцэтгэн, дүн мэдээг тухай бүр танилцуулахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн их эмч (Ц.Пүрвээ), (А.Сайнбилэг), (Б.Нямсүрэн) нарт тус тус даалгасугай.

3. Дархлаажуулалтын зар, мэдээг малчдад хүргэж, товлосон газарт мал сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон газар тогтоосон хугацаанд дархлаажуулалтын арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэн, малчдад үүрэг болгосугай.

4011001

MuDoc Zehirami /ZDTC/

4.Дархлаажуулалтын ажлын явц, технологийн мөрдөлт, зохион байгуулалт, мал сүргийн хамрагдалтад тогтмол хяналт тавин ажиллаж, гарсан зөрчил дутагдлыг тухай бүрт нь мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчид мэдээлэн ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Э.Нарангарав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ